

**“АГААРЫН ХӨЛГИЙГ ХУУЛЬ БУСААР БУЛААН АВАХ ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ  
ТУХАЙ КОНВЕНЦЫН НЭМЭЛТ ПРОТОКОЛ”-ЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТАЛААРХ АЮУЛГҮЙ  
БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тус Байнгын хороонд Хууль зүйн байнгын хорооноос “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76.4-т заасны дагуу 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ ирүүлснийг нэгтгэн хэлэлцсэн болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Баян-Өлгий аймгийн нисэх буудлын аэродромын өргөтгөлийн ажлын санхүүжилт шийдвэрлэгдсэн хэдий ч яагаад барилгын ажлыг эхлэхгүй байгаа талаар ажлын хэсгээс асуулт асууж, хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанаас “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.14.3-т заасныг үндэслэн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр эрхлэх асуудалд нь хамаарах Байнгын хороонд шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийн зөвшилцэх, хэлэлцүүлэхийг шийдвэрлэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАИНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

*Б.Энх-Амгалан*



ТУС3761 9020061300 9037164